

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн
2017 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2018/113/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954, 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Д.Назгүл

Утас:99427301 Цахим хаяг:nazgul_1972@yahoo.com

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2017 оны оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 03-наас 2 дугаар сарын 11-ний хооронд хийхээр төлөвлөн Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын аудитор Д.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2017 санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 23-нд аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 03-наас 2 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 12-нд Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3-р зүйлийн 3.1-д “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Байгууллагын дарга тус байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн захирагч төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Байгууллагын 2017 оны төсвийг аймгийн ТЕЗ-ийн тусгай шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн Төрийн сан, Цэнгэл сумын төрийн сангаар дамжуулан олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус цэцэрлэг нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох төв ХХК-ны “Аколоус” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Тусгай зориулалтын шилжүүлэгийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн төсвийн захирагч нь 2017 онд 242,8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 242,8 сая төгрөгийн санхүүжилт авч, банкин дахь харилцах дансны хүүгийн орлогоос 0,006 сая төгрөг оруулж бүгд 242,82 сая төгрөгөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн бүтцийг авч үзвэл нийт төсвийн 60,3 хувийг цалингийн зардал, 6,6 хувийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 33,1 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзлэж байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь шилэн дансны тухай хуулийн 6.1.1, 6.4.5 дахь заалтыг зөрчсөн тул 2017.12.20 01/56 тоот албан шаардлага өгч, 221.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийн биелэлтийг хангуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан болон хяналтын горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орлого, санхүүжилт, мөнгөн хөрөнгө, бараа материал, цалин, НДШ-ийн зардал, хоол, түлш халаалт, гэрэл цахилгаан, тэтгэмжийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Ажил гүйлгээ бага тул тус байгууллагын нийт орлого, нийт хөрөнгийг 15,4 хувь, нийт зардлын 95,5 хувийг хамруулж нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитаар санхүүгийн тайлан нөлөө үзүүлэхүйц материаллаг алдаа, зөрчил илэрээгүй. Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. НДШ-ийн ногдуулалт, төлөлтийн тооцоог шалгаж үзэхэд 2017 онд олгосон цалин хөлс, урамшуулал, нэг удаагийн тэтгэмж болон жирмэсэн, амаржсаны тэтгэмжид нийтдээ 32502,0 мянган төгрөгийн НДШ ногдуулж, 31873,5 мянган төгрөгийг төлж 628,6 мянган төгрөгийн өглөгтэй байх тооцоотой боловч санхүүгийн тайланд 725,9 мянган төгрөгийн өглөг харуулж, НД-ын байгууллагатай тооцоо нийлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд өглөгөөр илүү харуулсан 97,4 мянган төгрөгийн НДШ-ийг НД-ын байгууллагатай дахин тооцоо хийж, 2018 оны тооцоонд оруулахыг менежментийн захидлаар зөвлөмж болгов.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн үөрчлийг алдаа зөрчлийн маягтаар нэгтгэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цэнгэл сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:2018.02.11

Х.ЖЕНИСБЕК

Огноо:2018.02.12

Д.НАЗГҮЛ

Огноо:2018.02.12